

## **ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТУХАЙ**

УИХ-ын дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг та бид макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах амаргүй сорилт бүхий, эгзэгтэй цаг үед хэлэлцэж байна.

Монгол Улсын төлбөрийн тэнцэлд 2012 оны сүүлийн хагасаас эхэлж үүссэн дарамт нь 2013 онд хямралын шинжтэй болж, улмаар энэ нь 2013-2014 оны эдийн засгийн хүндрэлийн суурь учир шалтгаан болсон билээ. Сүүлийн 20 орчим сарын хугацаанд төлбөрийн нийт тэнцэл 2.8 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий 24%-тай тэнцэх хэмжээний алдагдалтай гарч, Монгол Улсын гадаад цэвэр актив 5.3 их наяд төгрөгөөр буураад байна. 2011-2012 оны дунджаар гадаадын шууд хөрөнгө оруулалт ДНБ-ий 40 гаруй хувийг эзэлж байсан бол 2013 онд 16 хувь, 2014 оны эхний хагаст ердөө 8 хувьтай тэнцэх хэмжээнд хүрч огцом буурлаа.

Ийнхүү сүүлийн 2 жилийн турш гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсан, гадаад худалдааны нөхцөл муудсан, эдийн засагт үлэмж нөлөө бүхий томоохон төслүүдийн хэрэгжилт он дамнан удааширч тодорхой бус байдал нэмэгдсэн, Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан зэрэг туйлын сөрөг орчинд мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, төлбөрийн тэнцлийн хүндрэлийн үед эдийн засгийг бүхэлд нь тогтворжуулах, эдийн засгийн суурь бүтэц, ажлын байрыг хамгаалах арга хэмжээ авсан гэж үзэж байна.

Монголбанк 2012 оны сүүлчээс эхлэн төрийн мөнгөний бодлогыг үнийн тогтвортой байдлын зорилтыг хангахын сацуу эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт, бүтцийн шинэчлэл, бодит секторын идэвхжилийг дэмжих, хуримтлал, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд тус тус чиглүүлж ирлээ. 2013-2014 оны төлбөрийн

тэнцлийн хямралтай орчинд төрийн мөнгөний бодлого нь дараах байдлаар хэрэгжлээ. Үүнд:

**Нэгд,** “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах хөтөлбөр”-ийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлснээр мах, гурил, жижиглэнгийн худалдааны шатахуун зэрэг иргэдийн хэрэглээний суурь бүтээгдэхүүний үнийн өсөлтийг эрс бууруулах, тогтвортой байлгах, дундаж давхаргын бодит орлогод ирэх ачааллыг зөөлрүүлэх, хэрэглээний суурь бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх зэрэг үр дүнд хүрч байна. Хөтөлбөрт хамрагдсан барааны үнийн өсөлт нь 2010-2012 онд дунджаар нийт инфляцийн 35%-ийг эзэлдэг байсан бол түүний инфляцид үзүүлэх шууд нөлөөлөл нь 2013 онд 2 дахин, 2014 оны эхний 9 сард 7 дахин буурч, инфляцийн бүтцэд тогтвортой, эерэг өөрчлөлт гарсаар байна.

**Хоёрт,** санхүүгийн салбарт зээлийн тасалдал үүсч болзошгүй байсан үед банкуудын төлбөрийн чадварыг хадгалах арга хэмжээ авснаар системийн хэмжээнд итгэлийг сэргээж, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжин, санхүүгийн салбарыг бүхэлд нь хамгаалсан. Банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээ 17 орчим хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 36 гаруй хувьтай байгаа нь Монголбанкнаас тавьдаг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хамгийн бага шаардлагаас харгалзан 5 нэгж хувь, 11 нэгж хувиар тус тус өндөр болж, санхүүгийн салбарын эрсдэл даах чадвар сайжирсан гэж үзэж байна.

**Гуравт,** инфляцийн хэтийн хандлага нь зорилтот түвшинтэй нийцтэй байсан үед мөнгөний бодлогын хүүг 2013 оны 1, 4, 6 дугаар саруудад, нийт 2.75 нэгж хувиар бууруулж, эдийн засгийн идэвхжилийг дэмжин, мөнгөний нийлүүлэлтийг бодит секторт эргэлтийн хөрөнгийн зээл олгох хэлбэрээр нэмэгдүүлсэн нь ДНБ-ий бодит өсөлтийг тогтворжуулах, ажлын байрыг хамгаалахад голлох нөлөө үзүүлсэн гэж үздэг. 2013 онд ДНБ-ий бодит өсөлт 11.7%-тай

гарсны 8.6 нэгж хувийн өсөлтөд мөнгөний уламжлалт бус тэлэх бодлого шууд нөлөөлсөн гэсэн тооцоотой байна.

**Дөрөвт,** “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлснээр өрхийн зардлын бүтцийг зохистой болгох замаар дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалж өрхийн төсөвт учрах нэмэлт ачааллыг нь зөөлрүүлсэн гэж үзэж байна. Энэхүү бодлого нь эдийн засгийн өсөлтийг хуримтлал болгодог загварт суурилснаараа дунд, урт хугацаанд инфляци буурах, эдийн засаг тогтвортой өсөх нэг чухал нөхцөлийг бүрдүүлж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш орон сууцны ипотекийн зээлийн үлдэгдэл 2.6 их наяд төгрөгт хүрч ДНБ-ий 13%-тай тэнцэх хэмжээнд, зээлдэгчдийн тоо 61 мянгад хүрлээ. Энэ нь хамгийн багадаа 120 мянган иргэн сар бүр өрхийн орлогынхоо 30-45 хувийг хуримтлал болгож, ипотекийн зээлийн төлбөрт дунджаар 30 тэрбум төгрөгийг сар бүр төвлөрүүлж байна гэсэн үг юм.

**Тавд,** гадаад валютын орох урсгалыг дэмжих, эдийн засаг дахь урт хугацаатай гадаад валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг Заавал байлгах нөөц (ЗБН)-ийн шаардлагаас чөлөөлсөн.

**Зургаад,** мөнгөний бодлогын хүүний нөлөөг сайжруулах, банк хоорондын захын хүүний хэлбэлзлийг бууруулах үүднээс 4 нэгж хувийн өргөнтэй хүүний коридорыг 2013 онд нэвтрүүлснээр Монголбанкнаас банкуудын авах санхүүжилтийн хүү буурч, 2013-2014 оны эдийн засгийн идэвхжилд эергээр нөлөөлсөн гэж үзэж байна. Банкны зээлийн жигнэсэн дундаж хүү 2013 оны 3 дугаар сард 19.5% байсан бол 2014 оны 9 дүгээр сард 16.3% болж 3.2 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Долоод**, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж уян хатан тогтох бодлогыг баримталж, эдийн засаг дахь гадаад орчны сөрөг нөлөөллийг төгрөгийн гадаад валюттай харьцах ханш болон гадаад валютын улсын нөөцөөр зөөлрүүллээ.

Үүний нөлөөгөөр 2009 оны хямралын үед 4 сарын хугацаанд 22.1%-иар суларч байсан төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш 2013-2014 онд 15 сарын хугацаанд 18.2%-иар суларсан байна. Энэ нь эдийн засаг, зах зээлийн сөрөг өөрчлөлтийн үед хувийн хэвшилд эрсдэлийг бууруулах боломж олгосон зайлшгүй шаардлагатай хугацаа, нөхцөл болж өгсөн юм.

Үүний үр дүнд гадаад худалдаа, урсгал тэнцэл, нийт эдийн засагт зайлшгүй шаардлагатай тохиргоо хийгдэж байгаа бөгөөд энэ нь санхүүгийн салбарт үүсч болзошгүй байсан сөрөг нөлөөллийг зөөлрүүлж, макро тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж байна.

Төлбөрийн тэнцлийн хүндрэлийн улмаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эрдэс, түүхий эдийн экспорт, гадаадын хөрөнгө оруулалт зонхилсон эдийн засагтай бусад орнуудын үндэсний валютын ханштай нэгэн адил суларсан юм. Гэхдээ манай орон уул уурхайн салбараас хамаарах хамаарлаараа тэдгээр орнуудаас бараг 3 дахин их хэдий ч, үндэсний валютын ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл нь гадаад валютын зах дахь тогтмол, идэвхтэй оролцооны үр дүн бусад орнуудаас 2 дахин бага үзүүлэлттэй байлаа.

2013-2014 оны төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалж төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш 2013 онд 15.5 хувиар, 2014 оны эхнээс 7.2 хувиар, бодит үйлчилж буй ханш 2013 онд 7.2 хувиар, 2014 оны эхнээс 3.2 хувиар тус тус суларсан. Ханшийн энэхүү өөрчлөлт нь богино хугацаанд тодорхой зардлыг дагуулсан хэдий ч, дунд болон урт хугацаанд дотоодын үйлдвэрлэл, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ажлын байрыг

хамгаалах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэхтэй нийцтэй гэж үзэж байна.

**Наймд,** төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд, урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор Монголбанк болон Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлөөс 2014 оны 3-р улиралд мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлж 12% болгох, гадаад валютын зээлийн эрсдэлээр жигнэх хувийг нэмэгдүүлэх, банкуудын зээлд эрсдэлийн санг нэмж байгуулах зэрэг шийдвэрүүдийг гаргаад байна.

**Есдүгээрт,** Хятадын ардын банкттай байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгтийн своп хэлцлийг санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, валютын зах дахь сөрөг нөлөөллийг зөөлрүүлэхэд ашиглаж байна. Энэхүү хэлцлийн хугацааг 2014 оны 5 дугаар сард 3 жилээр сунгаж, хэмжээг нь 8 дугаар сард 15 тэрбум юань болгож нэмэгдүүлээд байгаа нь гадаад валютын захыг тогтворжуулахад дэм боллоо.

**Аравт,** эдийн засгийн дунд хугацааны бүтцийн төрөлжилт, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, ашигт малтмалын бус салбарын экспортыг нэмэгдүүлэх зорилгоор ноолуурын үйлдвэрлэл болон экспорт, алт олборлолтыг дэмжих, барилгын материалын импортыг дотоодын үйлдвэрлэлээр орлуулахад чиглэсэн арга хэмжээг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байна.

Дээр дурдсан бодлогын цогц арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлсний үр дүнд эдийн засгийг тогтворжуулж, 2013-2014 онд санхүүгийн салбарт зээлийн тасалдал үүсэх, нийт М2 мөнгөний нийлүүлэлт огцом буурах, санхүүгийн салбарт системийн шинжтэй тогтворгүй байдал бий болох, эдийн засгийн хямрал нүүрлэх эрсдэлээс сэргийлж чадсан гэж дүгнэж байна.

УИХ-ын дарга, эрхэм гишүүдээ,

2014 оны эхнээс гадаад худалдаа тэнцвэржих эерэг хандлага гарч байгаа хэдий ч, гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргээгүй, гадаад актив буурсан, төлбөрийн нийт тэнцэл сайжраагүй хэвээр байна. Энэхүү нөхцөл байдал удаан үргэлжлэх нь эдийн засгийн өсөлт удаашрах, суурь инфляци өндөр байх, зээлийн өсөлт саарах, эдийн засгийн бодит сектор болон санхүүгийн салбарт эх үүсвэр хомсдох, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл нэмэгдэхэд тус тус нөлөөлсөөр байна.

Нэг талаас эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурсан, нөгөө талаас эдийн засгийг тогтворжуулах зорилгоор мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд эдийн засгийн бодит секторт хувийн хэвшлээр дамжуулж 2013 онд хийсэн мөнгөний нийлүүлэлт нь хөтөлбөрүүдийн зээлийн эргэн төлөлтөөр буурч байгаа нь эдийн засгийн өсөлт дэх нийт хөрөнгө оруулалтын нөлөөг 2014 оны сүүлийн хагас, 2015 онд бууруулахаар байна.

Төлбөрийн тэнцлийн хямралын нөлөөлөл арилахгүй байгаа нь макро эдийн засгийн бодлогын үндсэн сорилт болсоор байна. Цаашид гадаад валютын орох урсгал, төлбөрийн нийт тэнцэл эрс сайжрахгүй бол мөнгөний бодлогоор эдийн засгийн бодит секторыг дэмжих боломж, бодлогын сонголтууд хумигдаж, мөнгөний бодлогыг дахин чангаруулах шаардлага ч үүсч болзошгүй гэж үзэж байна.

Иймд, төлбөрийн тэнцлийн хямралаас гарч, эдийн засгийн хүндрэлийг арилгахын тулд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлэх, экспортын орлогыг сайжруулах, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх нь чухал хэвээр байна.

Энэ хүрээнд “Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний цогц төлөвлөгөө”-г баталж хэрэгжүүлэх, эдийн засагт үлэмж нөлөө бүхий төслүүдийн хэрэгжилтийг түргэтгэх, улсын өрийн

удирдлагын бодлогыг сайжруулах, хуулийн хүрээнд шинээр бүрдүүлэх гадаад валютын эх үүсвэрийг зөвхөн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхтэй уялдуулан ашигладаг байх нь зүйтэй гэж үзэж байна.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх нь 2015 онд болон дунд хугацаанд макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах, эдийн засгийн болзошгүй хямралаас сэргийлэхэд чухал үүрэгтэй байх болно гэж үзэж байна.

Эдийн засгийг хэлбэлзэл ихтэй дан ганц уул уурхайн салбараас хэт хамааралтай байлгах нь эдийн засгийн дархлаа сул, хуримтлал бага, төлбөрийн тэнцэл тогтворгүй, урт хугацаанд эдийн засаг тогтвортой өсөх нөхцөл бүрдэхгүй байхад нөлөөлж байна гэж дүгнэдэг. Иймд уул уурхайн салбарыг хөгжүүлэхийн сацуу эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх нь Монголын эдийн засагт тулгарсаар буй чухал асуудал хэвээр байна.

УИХ-ын эрхэм гишүүдээ,

2015 оны мөнгөний бодлогын үндсэн зорилт нь эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засаг дунд, урт хугацаанд тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчинг бүрдүүлэхэд чиглэх нь зүйтэй гэж үзэж байна.

Монголбанк макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, иргэдийн бодит орлогыг хамгаалах үүднээс дунд хугацаанд буюу 2015-2017 онд инфляцийг 7 хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгах зорилтыг дэвшүүлж байна.

Нийлүүлэлтийн гаралтай инфляци 2 дахь жилдээ дараалан буурч байна. Монголбанк “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөр дэх оролцоог анх хөтөлбөрийг эхлүүлэхдээ төлөвлөж байсныхаа дагуу шат дараатай бууруулж байгаа бөгөөд дунд хугацаанд хэрэглээний суурь бараа,

бүтээгдэхүүний нийлүүлэлтийн зах зээлийн зарчимд суурилсан тогтвортой тогтолцоо бүрдсэнээр цаашид нийлүүлэлтийн гаралтай инфляци нам түвшиндээ, тогтвортой байхаар байна. Ийм орчинд гадаад валютын орох урсгал, төлбөрийн тэнцлийг эрс сайжруулах замаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсны инфляци дахь нөлөөллийг бууруулснаар суурь инфляци буурч, инфляци дунд хугацааны зорилтот түвшин болох 7%-д байх боломжтой гэж үзсэн.

Монголбанк ханшийн өөрчлөлтийн хандлагыг өөрчлөлгүйгээр, зөвхөн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор валютын захад оролцох бодлогыг цаашид үргэлжлүүлнэ. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихүйц уян хатан тогтож, дунд хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахтай нийцтэй байх зарчмыг баримтална.

УИХ-ын эрхэм гишүүдээ,

Монголбанк санхүүгийн салбарын тогтвортой байдалд онцгой анхаарал хандуулдаг бөгөөд банкууд зохистой харьцааны болон өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүдээ бүрэн хангаж ажилласаар байна.

2015 онд банкуудын төлбөрийн чадварыг хадгалах хүрээнд өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх замаар системийн болзошгүй эрсдэлээс хамгаалах чадварыг нэмэгдүүлж, санхүүгийн салбарын дархлааг сайжруулна гэж үзсэн. Банкны системийн тогтвортой байдлыг хангах, активын өсөлтийг өөрийн хөрөнгөтэй нийцүүлэх хүрээнд банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд болон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шат дараатайгаар нэмэгдүүлэх талаар судалж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно.

Гадаад валютын ханшийн хэлбэлзэл болон бусад төрлийн эрсдэлүүдээс шалтгаалан зээлийн чанар муудахаас сэргийлэх, банкуудын зээлийн багц эдгээр эрсдэлд өртөмтгий эдийн засгийн



салбаруудад голчлон төвлөрөх үзэгдлийг бууруулах зорилгоор банкуудын үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтын онцлогтой нь уялдсан эрсдэлийн удирдлагыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Түүнчлэн, банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд банкны эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг үргэлжлүүлэх, үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох, банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн олгох хууль эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр ажиллана.

Монголбанк санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, дэвшилтэт технологид суурилсан банкны шинэлэг үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн банкны зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр ажиллана.

Үүний зэрэгцээ мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг илүү боловсронгуй болгож, мөнгөний бодлогын үндсэн зорилт, хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах ажлыг үргэлжлүүлэн, Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хадгална.

УИХ-ын эрхэм гишүүд ээ,

2015 онд хэрэгжүүлэх төрийн мөнгөний бодлогын үндсэн агуулгыг “нам, тогтвортой инфляци, санхүүгийн тогтвортой байдал ба макро эдийн засгийн тэнцвэр” хэмээн томъёолж байна.

УИХ-ын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэж, баталж өгөхийг хүсье.